



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/III

Чингис хот


Хөрөнгө зарцууг ах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4, 29.1.5, 29.1.6-ийн "м", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архивын тасгаас ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Архивын тасагт байгаа "Хэнтий" телевизийн 127 видео кассет буюу 381 цагийн мэдээ, нэвтрүүлгийн түүхэн бичлэгүүдийг видео файл болгож нэгтгэх зорилгоор иргэн Ренчиндаваа овогтой Мөнхболдтой байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд хамтран ажиллахад зориулан 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ